



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 9/587

Хэрлэн сум

Бичил уурхайн сургалт,
зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу шинэчлэн батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг орон нутаг хангуулах, аймаг орон нутагт баримтлах бодлого чиглэлийг танилцуулах, мэдээлэл өгөх, сумдын нөхцөл байдал, тайлан мэдээг сонсох, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулж буй “Бичил уурхай эрхлэгчдийн сургалт, зөвлөгөөн”-ий зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 11 дугаар сарын 20-ны
дугаар захирамжийн хавсралт

БИЧИЛ УУРХАЙН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зохион байгуулах арга хэмжээ | Тоо хэмжээ | Нэгж дүн /сая төгрөг/ | Нийт дүн /сая төгрөг/ |
|----------|------------------------------------------------------|-------------------|------------------------------|------------------------------|
| 1 | Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах гэрээт үйлчилгээ | 1 | 7,000,000 | 7,000,000 |
| | НИЙТ ДҮН | | 7,000,000 | |